

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГИЙН БАГЦЫГ ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙЖ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь үл хөдлөх хөрөнгийн барьцаатай баталгаат үнэт цаасыг бүртгэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд уг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлж буй үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан тухай тусгай тэмдэглэл /цаашид “тусгай тэмдэглэл” гэх/ хийж, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмын 1.1-д заасан тусгай тэмдэглэлийг хийхэд Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2010 оны 38 дугаар тушаалаар баталсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх” журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Эрхийн улсын бүртгэлд барьцааны тухай тусгай тэмдэглэл хийх

2.1. Тусгай тэмдэглэлийг хийхэд улсын бүртгэгч нь Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.2, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.4-т заасныг тус тус баримтлан эрхийн улсын бүртгэлд бүртгэнэ.

2.2. Эрх шилжүүлэн авч байгаа этгээд /цаашид “тусгай зориулалтын компани” гэх/ нь тусгай тэмдэглэл хийлгэх тухай хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оор уламжлуулан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн байгууллагад гаргах бөгөөд уг хүсэлтэд дараах баримт, материалыг хавсаргана:

2.2.1. баталгаат үнэт цаасыг бүртгэсэн тухай Хорооны шийдвэр;

2.2.2. Хороонд бүртгүүлсэн хөрөнгийн багц дахь үл хөдлөх хөрөнгийн жагсаалт;

2.2.3. хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн гэрээ;

2.2.4. тусгай зориулалтын компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар.

2.3. Улсын бүртгэгч нь энэ журмын 2.2-т заасан хүсэлт, холбогдох баримт, материалыг хүлээн авч тухайн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хувийн хэрэгт хавсаргаж бүртгэнэ.

2.4. Улсын бүртгэгч бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 3 хоногт багтаан эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд уг тэмдэглэл хийгдсэн бол энэ талаар хүсэлт ирүүлсэн этгээдэд хариу албан бичгээр мэдэгдэнэ.

2.5. Тэмдэглэлийг улсын бүртгэлд бүртгэхэд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.5-д зааснаар үйлчилгээний хөлс авахгүй.

2.6. Тусгай зориулалтын компани шаардлагатай бол уг бүртгэлд хийгдсэн эсэх талаарх лавлагаа авч болно.

Гурав. Эрхийн улсын бүртгэлд хийгдэх тэмдэглэлийн агуулга

3.1. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцтай холбоотой тусгай тэмдэглэл “хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.4-т заасны дагуу тусгай тэмдэглэл хийж бүртгэв” гэсэн агуулгатай “бүртгэв” тэмдэг дарж, гарын үсэг зурна.

3.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан үүрэг гүйцэтгэгчийн үүрэг дуусгавар болж, тусгай зориулалтын компаниас тусгай тэмдэглэлийг хүчингүй болгох хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд энэ журамд заасан тусгай тэмдэглэлд зөвхөн Хорооны шийдвэрээр өөрчлөлт оруулна.

3.3. Энэ журмын 3.2-т зааснаар тусгай зориулалтын компани тусгай тэмдэглэлийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан бол энэ тухай эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт тэмдэглэл хийж хаана.

---oOo---